



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2024 оны 11 сарын 25 өдөр

Дугаар 4/466

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа  
эрхлэх тусгай зөвшөөрлийн  
хугацаа сунгах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.17, 19.18 дахь хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх заалт, Тусгай зөвшөөрлийн комиссын 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 10 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах байгууллагын нэрсийг хавсралтаар баталсугай.
2. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналтын газар (О.Энхболд)-т үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбатад даалгасугай.

САЙД



Т.МӨНХСАЙХАН

Эрүүл мэндийн сайдын 2024 оны  
11 дүгээр сарын 26 өдрийн 8/452  
дугаар тушаалын хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААГ СУНГАХ  
БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ

№	Байгууллагын нэр	Тусгай зөвшөөрлийн төрөл, чиглэл	Хаяг байршил	Хүчинтэй хугацаа
1	Улсын гуравдугаар төв эмнэлэг УБД: 9070001140 РД: 9077154	Эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээ (Төрөлжсөн мэргэшлийн төв)	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 5-р хороо, Ард Аюушийн гудамж 1А	2029.12.30
2	Грандмед эмнэлэг УБД: 9011103029 РД: 5143152	Эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээ (Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг)	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороо, Ар Зайсангийн гудамж 104 тоот	2029.11.25

---000---